



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/19

Есөнбулаг сум

Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1. дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэхь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаал, Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам батлах тухай" 259 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, барилга байгууламжийн паспортжуулалтын дүгнэлт гаргах эрх бүхий хуулийн этгээдийг мэргэжил арга зүй, удирдлагаар хангах, барилга байгууламжийн бат бэх, найдваржилтын түвшин, төлөв байдлыг хэлэлцэн шийдвэр гаргах үүрэг бүхий аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд: (Аймгийн Ерөнхий архитектор)

(Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

(Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтцийн хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)

("Ундарга-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер)

("Солонго дулааны станц" ААТҮГ-ын ерөнхий инженер)

(Аймгийн барилгын салбарын төлөөлөл) (Монгол Улсын зөвлөх инженер)

Нарийн бичгийн дарга: (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

2.Барилга байгууламжийг паспортжуулах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулж, ажлын явцыг тухай бүр танилцуулахыг зөвлөл(аймгийн Засаг даргын орлогч)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

